

## ИХ ДҮНТЭЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ЖУРАМ

### НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь заалт, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн дагуу төлбөрийн системийн оролцогч хоорондын их дүнтэй төлбөр тооцоог үнэн зөв, тасралтгүй найдвартай гүйцэтгэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2 Оролцогч нь “Банксүлжээ” системийн үйл ажиллагаанд оролцохдоо Монголбанкттай “Их дүнтэй төлбөрийн системийн оролцогчтой байгуулах гэрээ”-г байгуулна.

### ХОЁР.НЭР ТОМЬЁО

- 2.1 Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:
- 2.1.1 “Банксүлжээ систем” гэж их дүнтэй төлбөр тооцоог нэг бүрчлэн бодит цагийн горимд гүйцэтгэж буй Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.2-т заасан цогц бүтцийг;
- 2.1.2 “Гүйлгээ” гэж Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.18-д заасан шилжүүлгийн Банксүлжээ системээр дамжих цахим хэлбэрийг;
- 2.1.3 “Их дүнтэй төлбөр тооцоо” гэж Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.26-д заасан, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан хязгаараас дээш үнийн дүнтэй оролцогч хоорондын гүйлгээ, түүний төлбөр тооцоог;
- 2.1.4 “Оролцогч” гэж Банксүлжээ системд оролцох “Үндэсний төлбөрийн системийн тухай” хуулийн 5.1.7-д заасан этгээдийг;
- 2.1.5 “Хэрэглэгч” гэж “Үндэснийн төлбөрийн системийн тухай хууль”-ийн 5.1.10-т заасныг;

### ГУРАВ.“БАНКСҮЛЖЭЭ” СИСТЕМИЙН ОРОЛЦОГЧ

- 3.1 Их дүнтэй төлбөрийн системд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, арилжааны төлбөр тооцоог төвлөрүүлэн гүйцэтгэх эрх бүхий этгээд, банк, банкны эрх хүлээн авагч оролцоно.
- 3.2 “Банксүлжээ” системд оролцогч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 12.1-т заасан болон дараах шаардлагыг хангасан байна:

3.2.1 Тухайн этгээдийн гүйлгээ болон төлбөр тооцоог “Банксүлжээ” системээр дамжуулах тухай холбогдох шийдвэрийг Монголбанкнаас гаргасан байх;

3.2.2 Монголбанкинд харилцах данс нээлгэсэн байх;

3.2.3 Монголбанктай “Их дүнтэй төлбөрийн системийн оролцогчтой байгуулах гэрээ”-г байгуулсан байх;

3.2.4 Банксүлжээ системд шууд холбогдсон байх;

3.2.5 “Банксүлжээ” системд оролцогч тус бүр нь БИК кодтой байна. (Хоёрдугаар хавсралт)

3.2.6 Оролцогч, түүний салбар нэгжийг ялгах зорилгоор Монголбанкнаас олгосон тусгай кодыг БИК код гэж ойлгоно.

3.3 “Банксүлжээ” системд оролцогч нь дараах үүргийг хүлээнэ:

3.3.1 Монголбанкнаас баталсан “Төлбөрийн системд мөрдөх мэдээллийн технологийн тасралтгүй, найдвартай ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллана.

3.3.2 “Банксүлжээ” систем рүү илгээж буй гүйлгээ бүрт хүлээн авагчийн дансны нэр, дугаар, банкны нэр, мөнгөн дүн, гүйлгээний утга зэрэг мэдээллийг тодорхой заасан байна.

3.3.3 Оролцогч нь хэрэглэгчийн гүйлгээг өөрийн системд оруулснаас хойш 1 (нэг) цагийн дотор “Банксүлжээ” системд илгээнэ.

3.3.4 Оролцогч нь их дүнтэй гүйлгээг зөвхөн өөрийн төв салбараар дамжуулан “Банксүлжээ” системд илгээж, хүлээн авна.

3.3.5 Оролцогч нь өөрийн нягтлан бодох бүртгэлийн системдээ дараах дансдыг нээнэ:

- “Дамжуулалтын данс” гэсэн пассив шинжтэй дансыг нээж, түүгээр дамжуулан гүйлгээ хийх ба “Банксүлжээ” системийн хаалтын цагаас хойш салбар, нэгжүүдээс ирсэн гүйлгээг тус дансанд бүртгэж, дараагийн ажлын өдрийн эхний гүйлгээнд оруулна.
- “Саатлын данс” гэсэн пассив шинжтэй дансыг нээж, Монголбанкин дахь харилцах дансны үлдэгдэл хүрэлцээгүйн улмаас түр саатсан эсвэл “Банксүлжээ” системээс буцаасан гүйлгээг салбар, нэгжээс ирсэн хугацааны дарааллаар бүртгэнэ.

3.3.6 Хэрэглэгчийн гүйлгээг саатуулснаас үүссэн хохирол, торгуулийг төлбөр гүйцэтгэж буй оролцогч хариуцна.

3.3.7 Оролцогч нь нэр, данс зөрсөн эсхүл хаагдсан дансны дугаар бүхий гүйлгээг хүлээн авсан даруй буцаалтын гүйлгээг хийх ба буцаалтын гүйлгээг хүний оролцоогүй (автоматаар) үүсгэж, Банксүлжээ системийн **pacs.004** мэдээний төрлийн дагуу дамжуулна.

3.3.8 “Банксүлжээ” системийн цаг хаагдахаас өмнө буцаалтын гүйлгээг дамжуулаагүй оролцогч нь дараагийн ажлын өдрийн эхний гүйлгээгээр дамжуулна.

3.3.9 Оролцогч нь нэр, данс зөрсөн эсвэл хаагдсан дансны дугаар бүхий гүйлгээнээс бусад гүйлгээг буцаалтын гүйлгээгээр дамжуулахгүй байх нөхцөлийг хангаж ажиллана.

3.3.10 Оролцогч нь Монголбанкнаас тавьсан техникийн шаардлагыг бүрэн хангасан байна.

3.3.11 Буцаалтын гүйлгээнээс оролцогч болон Монголбанк шимтгэл тооцож авахгүй.

## ДӨРӨВ.ТӨЛБӨР ТООЦОО ГҮЙЦЭТГЭХ

4.1 “Банксүлжээ” системээр дараах их дүнтэй төлбөр тооцоог дамжуулна:

- Оролцогч хоорондын төгрөгийн их дүнтэй төлбөр тооцоо;
- Оролцогчийн төлбөрийн чадварыг хангуулахтай холбоотой хийгдэх банк хоорондын зээл, хадгаламж, репо арилжаа, овернайт репо санхүүжилт;
- Овернайт хадгаламж;
- Бэлэн мөнгөний чек, үнэт цаас, аккредитивтай холбоотой гүйлгээ;
- Клирингийн системийн үр дүнгийн төлбөр тооцоо;
- Орон нутаг дахь банкны салбарууд төв салбараас бэлэн мөнгөний зузаатгал авах болон өгөх гүйлгээ;

4.2 Гүйлгээний мөнгөн дүнгээс үл хамааран “Банксүлжээ” системээр оролцогч хоорондын дараах валютын гүйлгээг тухайн оролцогчийн Монголбанк дээрх валютын харилцах дансаар дамжуулж болно:

- Валютын харилцах, хадгаламж байршуулах;
- Данс зузаатгал;
- Харилцан тохиролцсоны үндсэнд хийгдэх валют арилжааны гүйлгээ;
- Гадаад валютаар илэрхийлэгдсэн үнэт цаасыг худалдах, худалдан авах гүйлгээ;
- Зээл, зээлийн хүүг өгөх, авах, эргэн төлөх;
- Санхүүгийн үүсмэл хэрэгсэлтэй холбоотой валютын гүйлгээ;

4.3 Монголбанк нь оролцогчийн харилцах данснаас зөвхөн дараах тохиолдолд зарлагын гүйлгээ хийнэ:

- Тухайн оролцогч зөвшөөрсөн;
- Клирингийн системийн үр дүнгийн төлбөр тооцоог гүйцэтгэх;
- Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал, шийдвэр гарсан;
- Шүүхийн шийдвэр гарсан;
- Улсын байцаагчийн шийтгэвэрийн хуудас өгсөн;
- Монголбанкинд тушаасан бэлэн мөнгөний илүүдэл, дутагдлын акт гарсан.

4.4 Монголбанкнаас илгээсэн оролцогчийн харилцах данстай харьцах болон энэ журмын 4.3-т заасан гүйлгээг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан их, бага дүнтэй гүйлгээний хязгаарыг үл харгалзан “Банксүлжээ” системээр дамжуулна.

4.5 “Банксүлжээ” системээр дамжих гүйлгээ бүр үл давтагдах дугаартай байна.

4.6 “Банксүлжээ” систем нь зөвхөн тухайн ажлын өдрийн /current Value Date/ их дүнтэй төлбөр тооцоог гүйцэтгэх бөгөөд түүнээс өөр бусад өдрийн төлбөр тооцоог гүйцэтгэхгүй.

4.7 Шаардлагатай тохиолдолд “Банксүлжээ” систем дээр оролцогчийн тусгай дансыг нээж болно. Тусгай данс нь дараах хүрээг хамарна:

- Репо хэлэлцээрийн төлбөр тооцооны тусгай данс,
- Улсын нөөц байршуулах тусгай данс /Засгийн газар, Сангийн яам/,
- Улсын гаалийн ерөнхий газрын тусгай данс,
- Заавал байлгах нөөцийн данс,
- Бусад шаардлагатай данс.

4.8 Энэ журмын 4.2-т заасан валютын харилцах дансаар зөвхөн оролцогч хоорондын гадаад валютын гүйлгээг дамжуулах бөгөөд хэрэглэгчийн гадаад валютын гүйлгээг дамжуулахгүй.

4.9 “Банксүлжээ” системээр төлбөр гүйцэтгэгч оролцогчийн харилцах данснаас дебит гүйлгээ, төлбөр хүлээн авагч оролцогчийн харилцах дансанд кредит гүйлгээг нэгэн зэрэг хийсэн даруйд тухайн төлбөр тооцоог эцсийн бөгөөд үл буцаагдах гэж тооцно.

## ТАВ.АЖИЛЛАХ ХУВААРЬ

5.1 “Банксүлжээ” систем нь ажлын өдрүүдэд дор дурьдсан хуваарийн дагуу ажиллана.

*Хүснэгт 1. “Банксүлжээ” системийн ажиллах цагийн хуваарь*

Д/д	Үйл явц	Эхлэх	Төгсөх	
1	Өдөр нээгдэх		09.00	
2	Овернайт хадгаламжийг буцаах, түүний хүүг төлөх, овернайт репо санхүүжилт төлөх гүйлгээ	09.00	09.10	
3	Гүйлгээ дамжуулах	Хэрэглэгчийн гүйлгээ (рас.008)	09.10	16.30
		Санхүүгийн байгууллага хоорондын төгрөгийн гүйлгээ (рас.009)	09.10	17.10
		Санхүүгийн байгууллага хоорондын валютын гүйлгээ (рас.009)	09.10	17.00
4	Гүйлгээ дамжуулалт зогсох Дараалалд буй гүйлгээг цуцлах	17.10	17.11	
5	Овернайт репо санхүүжилт, овернайт хадгаламжийн гүйлгээ дамжуулах	17.11	17.20	
6	Гүйлгээ дамжуулалт зогсох Дараалалд буй гүйлгээг цуцлах Дансны хуулга илгээх Шимтгэлийн мэдээ бэлтгэх Гүйлгээ архивлах	17.20	18.00	
7	Өдөр өндөрлөх	18.00		

5.2 Монголбанк ажлын өдрийн 09.10-16.30 цаг хүртэл хэрэглэгчийн төгрөгөөр хийгдэх их дүнтэй гүйлгээг, 09.10-17.10 цаг хүртэл санхүүгийн байгууллага хоорондын төгрөгийн их дүнтэй гүйлгээг, 09.10-17.00 цаг хүртэл оролцогч хоорондын валютын гүйлгээг тус тус дамжуулна. Тухайн өдрийн 17.11-17.20 цаг хүртэл хийх овернайт репо

санхүүжилт болон овернайт хадгаламжийн гүйлгээ нь “Банксүлжээ” системээр дамжуулах сүүлчийн гүйлгээ болно.

5.3 Монголбанкны холбогдох газар нь овернайт репо санхүүжилт, овернайт хадгаламжийн гүйлгээний шийдвэрийг Банк хоорондын цахим арилжааны системээр дамжуулан тухайн ажлын өдрийн 17.15 цагт Монголбанкны Тайлан бүртгэлийн газарт хүргүүлнэ.

5.4 “Банксүлжээ” системийн гүйлгээ дамжуулалт зогссоноос хойш тухайн өдрийн алдаатай гүйлгээг залруулах зорилгоор цаг сунгах тохиолдолд Монголбанкны Төлбөр тооцооны газрын захирал шийдвэр гаргаж, холбогдох газарт мэдэгдэнэ. (Нэгдүгээр хавсралт)

5.5 Тухайн өдрийн алдаатай гүйлгээг залруулахдаа зарлагын гүйлгээ хийж байгаа банкны Монголбанкинд байршуулсан овернайт хадгаламжийн гүйлгээг дараах тохиолдолд цуцална:

- Залруулгын гүйлгээ хийснээр тухайн банк нь заавал байлгах нөөцийн шаардлагыг хангаж чадахгүйд хүрсэн;
- Залруулгын гүйлгээг хийхэд тухайн банкны дансны үлдэгдэл хүрэхгүй болсон.

5.6 Оролцогчийн хийсэн алдаатай гүйлгээг “Банксүлжээ” системийн гүйлгээ дамжуулалт зогссоноос хойш буцааж залруулах тохиолдолд Монголбанкны “Үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-ийн 1.1-т заасан шимтгэлийг тооцно.

5.7 Байгалийн давагдашгүй хүчин зүйл /үер, ус, гал, газар хөдлөлт гэх мэт/ болон ямарваа нэгэн хор хөнөөлтэй үйл ажиллагаа, улс, орон нутагт тогтоосон онцгой байдал зэрэг урьдчилан таамаглах боломжгүй байдал үүссэн, эсхүл Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрээр энэ журмын 5.1-д заасан ажиллах цагийн хуваарийг мөрдөхгүй байж болно.

## ЗУРГАА. ГҮЙЛГЭЭНИЙ ДАРААЛЛЫН ЗОХИЦУУЛАЛТ

6.1 Тухайн оролцогчийн харилцах дансан дахь үлдэгдэл хүрэлцэхгүйн улмаас төлбөр тооцоо хийгдээгүй хүлээгдэж байгаа гүйлгээний жагсаалтыг дараалал гэж ойлгоно.

6.2 Оролцогчийн харилцах дансны үлдэгдэл хангалтгүй тохиолдолд тухайн оролцогчийн илгээсэн гүйлгээг “Банксүлжээ” систем “Эрэмбэ+FIFO” зарчмын дагуу дараалалд оруулах ба хаалтын цагийн үед эх үүсвэр хүрэлцэхгүй нөхцөлд дараалалд орсон гүйлгээг “Банксүлжээ” систем цуцална.

6.3 Ач холбогдлыг нь харгалзан үзэж, оролцогчоос тухайн гүйлгээнд олгосон тусгай дугаарыг эрэмбэ гэнэ.

6.4 Дараалалд хүлээгдэж буй гүйлгээг оролцогчийн харилцах дансанд эх үүсвэр орж ирсэн даруйд дарааллынх нь дагуу дамжуулна.

6.5 Оролцогч нь дараалалд орсон өөрийн гүйлгээг цуцлах боломжтой ба төлбөр тооцоо хийгдсэн гүйлгээг цуцлах боломжгүй.

6.6 Монголбанкнаас хийж буй их дүнтэй төлбөр тооцоо нь “эрэмбэ+FIFO” дараалалд хамаарагдахгүйгээр эхэлж хийгдэнэ.

6.7 Эрэмбэ нь 1-99 хооронд дугаарлагдах ба эрэмбийн дугаар өсөх тусам гүйлгээний ач холбогдол буурна.

6.8 Оролцогч нь “Банксүлжээ” системд дараалалд орсон гүйлгээнийхээ эрэмбийг дараах байдлаар өөрчилж болно:

- Гүйлгээний эрэмбийг өөрчлөх;
- Гүйлгээг цуцлах.

6.9 “Банксүлжээ” систем нь түгжрэлийг шийдвэрлэх механизмтай байх ба түгжрэл үүссэн тухай бүр зохицуулалт хийж болно.

6.10 Оролцогчийн харилцах дансны үлдэгдэл хүрэлцэхгүйн улмаас төлбөр тооцоо гүйцэтгэх боломжгүй болж, бусад оролцогчийн төлбөрийн чадварт нөлөөлснөөр тэдгээрээс өөрт хүлээн авах төлбөр тооцоо саатахыг түгжрэл гэнэ.

## ДОЛОО.ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

7.1 Монголбанк нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 39.1 дэх хэсэгт заасны дагуу төлбөрийн найдвартай, аюулгүй байдлыг хангах, үүсч болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрээр ажлын өдөр эхлэх бүрт оролцогчийн харилцах дансанд тодорхой дүнг барьцаа хэлбэрээр барьж болно.

7.2 Энэ журмын 7.1-д заасан барьцаа хэлбэрээр барьсан хөрөнгийг зөвхөн клирингийн системийн үр дүнгийн төлбөр тооцоог саадгүй гүйцэтгэх зорилгоор ашиглах ба үр дүнгийн төлбөр тооцоог амжилттай гүйцэтгэсний дараа чөлөөлж оролцогч нь тухайн хөрөнгийг төлбөр тооцоонд ашиглах эрх нээгдэнэ.

7.3 Оролцогч нь төлбөр тооцоог саадгүй гүйцэтгэх үүднээс “Төв банкны өдрийн зээлийн журам”-ын дагуу Монголбанкнаас эх үүсвэр зээлж болно.

## НАЙМ.ТӨЛБӨР ТООЦООГ ЗОГСООХ

8.1 Монголбанк нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 19.1-т заасан болон дараах үндэслэлээр оролцогчийн их дүнтэй төлбөр тооцоог түр зогсооно:

- Энэхүү журмыг мөрдөх боломжгүй болсон эсхүл удаа дараа зөрчсөн;
- Төлбөр гүйцэтгэх чадваргүй болсон;
- Тухайн оролцогчийн үйл ажиллагааны эрсдэлээс хамаарч системийн эрсдэл үүсэх нөхцөл байдал бий болсон.

8.2 Монголбанк оролцогчийн төлбөр тооцоог түр зогсоосон тухай мэдээллийг бусад оролцогчдод яаралтай мэдэгдэнэ.

8.3 Монголбанкнаас оролцогчийн төлбөр тооцоог түр зогсоох тухай мэдээллийг хүлээн авсан бусад оролцогчид нь тухайн оролцогчтой холбоотой дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Гүйлгээг нь дамжуулахгүй байх;

- Харилцах, хадгаламжийн болон бусад дансдын эрх нь хаагдахаас өмнөх төлбөрийг барагдуулах.

**ЕС."БАНКСҮЛЖЭЭ" СИСТЕМД АШИГЛАГДАХ  
МЭДЭЭНИЙ ТӨРӨЛ БА КОД**

9.1 Оролцогч нь “Банксүлжээ” систем рүү гүйлгээг цахим хэлбэрээр илгээхдээ дараах мэдээний төрлийг ашиглана:

Мэдээний төрөл	Тайлбар
рас.008	Хэрэглэгчийн гүйлгээ (төлбөр хариуцагч болон хүлээн авагч нь хоёулаа, эсвэл аль нэг нь хэрэглэгч байх)
рас.009	Санхүүгийн байгууллага хоорондын гүйлгээ (төлбөр хариуцагч болон хүлээн авагч нь оролцогч байх)
рас.002	Гүйлгээний төлөвийн талаарх мэдээ
рас.004	Буцаалтын гүйлгээ

9.2 “Банксүлжээ” систем нь дараах үндсэн мэдээг оролцогчдод илгээж болно:

Мэдээний төрөл	Тайлбар
самт.054 Дебит нотолгоо	Тухайн оролцогчийн данснаас төлбөр хасагдсан мэдэгдэл
самт.054 Кредит нотолгоо	Тухайн оролцогчийн дансанд төлбөр орсон мэдэгдэл
самт.033 Хуулга	Дансны хуулга
самт.998 Чөлөөт мэдээ	Зарлал, анхааруулга, бусад мэдээлэл дамжуулах

9.3 “Банксүлжээ” системээс оролцогчдод буцаасан болон цуцалсан мэдээний шалтгааныг агуулсан мэдээг илгээнэ.

**АРАВ.СИСТЕМИЙН НУУЦЛАЛ,  
АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

10.1 “Банксүлжээ” систем нь мэдээллийн аюулгүй байдал, дараалалд буй гүйлгээ ба оролцогчийн нэвтрэх эрхийн аюулгүй байдлыг бүрэн хангана.

10.2 “Банксүлжээ” системд илгээхээс өмнөх гүйлгээний аюулгүй байдал, нууцлалыг тухайн оролцогч бүрэн хариуцна.

10.3 “Банксүлжээ” системд илгээсэн гүйлгээний тоо баримт, өгөгдлийн үнэн зөв байдлыг тухайн оролцогч бүрэн хариуцна.

10.4 “Банксүлжээ” системийн үйл ажиллагааны нууцлалыг хангах зорилгоор оролцогч нь доорхи үүргийг хүлээнэ:

10.4.1 “Банксүлжээ” системээр дамжин хийгдэж байгаа гүйлгээний мэдээллийг нууцлах,

10.4.2 “Банксүлжээ” системийн аюулгүй, найдвартай, тасралтгүй байдалд сөргөөр нөлөөлж болохуйц төлбөр тооцооны системийн үйл ажиллагааны бүхий л хэлбэрүүдийг нууцлах, төлбөр тооцооны системийн техник хангамж нийлүүлэгч байгууллага, ажилтан болон бусад холбогдох хувь хүмүүс энэхүү нууцыг хадгалах.

10.5 Монголбанк нь зөвхөн дараах мэдээллийг нийтэлж болно:

10.5.1 “Банксүлжээ” системээр дамжин хийгдсэн гүйлгээний нийт тоо, дүн зэрэг цогц мэдээлэл,

10.5.2 “Банксүлжээ” системийн талаарх тайлбар мэдээлэл.

## АРВАН НЭГ.ТАСРАЛТГҮЙ АЖИЛЛАГАА

11.1 Төлбөр тооцооны системд саатал, эвдрэл гарах үед мэдээлэл солилцох үүднээс мэдээллийн технологийн болон төлбөр тооцоо хариуцсан албан тушаалтан, тэдгээрийг орлох албан тушаалтны нэрсийн жагсаалт, холбоо барих утас зэрэг мэдээллийг оролцогч бүр Монголбанкинд албан ёсоор хүргүүлж, нэрсийн жагсаалтад өөрчлөлт орох бүрт мэдэгдэнэ. (Дөрөвдүгээр хавсралт)

11.2 “Банксүлжээ” систем болон оролцогч хооронд дамжин хийгдэж байгаа их дүнтэй төлбөр тооцоо саатах, эсхүл саатаж болзошгүй тохиолдлуудыг төлбөр тооцооны системийн саатал гэнэ.

11.3 Төлбөр тооцооны системийн саатал нь дараах 3 төрөл байна:

- Оролцогчийн системийн,
- “Банксүлжээ” системийн,
- Бусад.

11.4 Оролцогчийн системийн саатал:

11.4.1 Оролцогчийн системд саатал гарч, гүйлгээ хийх, мэдээлэл солилцох боломжгүй болсон тохиолдолд тухайн оролцогч саатал гарснаас хойш 15 минутын дотор Монголбанкинд мэдэгдэнэ.

11.4.2 Тухайн оролцогчийн системийн саатал нь нийт төлбөр тооцооны системд доголдол үүсгэх аюултай буюу уг саатал сунжрах магадлалтай нөхцөлд тухайн оролцогч нь саатал гарснаас хойш 30 минутын дотор бусад оролцогчдод мэдэгдэнэ. Бусад оролцогч нь тухайн саатал гарсан оролцогч руу гүйлгээ илгээх эсэхийг өөрсдөө шийдвэрлэнэ.

11.4.3 Энэ журмын 11.3.2-т заасан мэдэгдлийг илгээсэн болон хүлээн авсан оролцогч нь саатлын тухай үнэн зөв мэдээллийг холбогдох хэрэглэгчдэд өгнө.

11.4.4 Тухайн оролцогч нь системийн саатлыг яаралтай сэргээн засварлаж, “Банксүлжээ” системд эргэн холбогдоно.

11.4.5 Оролцогч нь “Банксүлжээ” системд эргэн холбогдох боломжгүй болсон бөгөөд холболт хэвийн болохоос өмнө гүйлгээ хийх шаардлагатай тохиолдолд дискээр гүйлгээг авчирч “Банксүлжээ” системээр гүйлгээ дамжуулж болно.

11.4.6 Онцгой нөхцөлд тухайн оролцогчийн **pacs.009** төрлийн яаралтай гүйлгээг төлбөрийн даалгаварт үндэслэн Монголбанк гүйцэтгэж болно.

11.4.7 Цаасан болон цахим хэлбэртэй, мөнгөн хөрөнгийг шилжүүлэх даалгаврыг төлбөрийн даалгавар гэнэ.

11.5 “Банксүлжээ” системийн саатал:



11.5.1 “Банксүлжээ” системд саатал гарсан тохиолдолд Монголбанк оролцогчдын мэдээллийн технологийн болон төлбөр тооцоо хариуцсан албан тушаалтнуудтай цаашид авах арга хэмжээний талаар зөвшилцөнө. Монголбанк дараах дүгнэлтийг гаргасан нөхцөлд “дискээр гүйлгээ дамжуулах ажиллагаа”-г эхлүүлнэ:

- Өдрийн эцэс хүртэлх хугацаанд саатлыг арилгах боломжгүй,
- Нөөц төвөөр төлбөр тооцоо гүйцэтгэх боломжгүй,
- Өдрийн эцэс хүртэлх үндсэн хугацаанд дискээр гүйлгээ дамжуулах үйл ажиллагааг гүйцэтгэх боломжтой.

11.5.2 Мэдээлэл хадгалах зөөврийн төхөөрөмжийг диск гэнэ.

11.5.3 Оролцогч нь дискээр гүйлгээ үүсгэн дамжуулах эсэх тухайгаа Монголбанкинд нэн даруй мэдэгдэнэ.

11.5.4 Дискээр гүйлгээ дамжуулах хугацааг Монголбанк зарлах бөгөөд ингэхдээ оролцогчдоос дискээр гүйлгээ хүлээн авах, хүлээн авсан гүйлгээг хуваарилах хугацааг тус тус зааж өгнө.

11.5.5 Монголбанкнаас зарласан хугацааны дагуу тухайн оролцогчийн итгэмжлэгдсэн ажилтан нь Монголбанкинд биеэр ирж “Банксүлжээ” системээр гүйлгээг дамжуулна.

11.5.6 Дискээр гүйлгээ дамжуулах болон хүлээн авах явцад учирч болзошгүй гүйлгээ давхардах зэрэг эрсдэлийг гүйлгээ дамжуулсан оролцогч хариуцна, анхаарч ажиллана.

11.5.7 Монголбанк төлбөр тооцооны системийн найдвартай, аюулгүй ажиллагааг баталгаажуулах үүднээс “Төлбөр тооцооны системийн онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөө”-ний дагуу “Банксүлжээ” системийн туршилтыг жилд 1 удаа гүйцэтгэнэ. Туршилтын явцад бүх оролцогчид хамтран оролцоно.

11.5.8 “Банксүлжээ” системийн саатлын улмаас нөөц төв рүү шилжих шаардлага гарсан нөхцөлд оролцогчид Монголбанкнаас өгөх зааврыг дагаж мөрдөнө.

11.5.9 Үндсэн төвд онцгой байдал<sup>1</sup> үүсэх үед төлбөрийн системийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор байгуулсан, мэдээллийн технологийн нөөц систем, түүний техник төхөөрөмжийн байгаа байршлыг нөөц төв гэнэ.

## АРВАН ХОЁР.СИСТЕМИЙН ӨӨРЧЛӨЛТ, ХЯНАЛТ

12.1 “Банксүлжээ” системд өөрчлөлт хийхтэй холбогдуулан Монголбанкнаас дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

12.1.1 Албан ёсны мэдэгдэл, холбогдох зааврыг өөрчлөлт хийгдэхээс өмнө оролцогчдод хүргүүлэх,

12.1.2 Журам, заавар болон бусад баримт бичигт шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг оруулах,

---

<sup>1</sup>техник, програм хангамжийн алдаа, хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл, гал түймэр, газар хөдлөлт, хүчтэй салхи, үер, аянга зэрэг гэнэтийн осол, байгалийн гамшиг болон бусад шалтгаанаар мэдээллийн технологийн системийн хэвийн үйл ажиллагаа алдагдахыг.

12.1.3 Өөрчлөлт хийхээс өмнө оролцогчидтой хамтран зайлшгүй турших, шаардлагатай гэж үзвэл туршилтын явцад Монголбанкны зүгээс оролцогчдод туслалцаа үзүүлнэ.

#### АРВАН ГУРАВ.ХӨЛС, ШИМТГЭЛ

13.1 Монголбанкны “Үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-ийн дагуу оролцогчдын гүйлгээнд Монголбанк шимтгэл тооцож, тухайн оролцогчийн харилцах данснаас үл маргах журмаар дараа сарын ажлын эхний 3 хоногийн дотор суутган авна.

13.2 Монголбанк нь дараах үндэслэлээр шимтгэлийн хэмжээг өөрчлөн тогтоох эрхтэй:

13.2.1 Мэдээллийн технологийн ба техник, програм хангамжийн үйлчилгээ шинээр нэвтрүүлснээр үйл ажиллагааны болон үйлчилгээний зардалд мэдэгдэхүйц өөрчлөлт орсон,

13.2.2 Монгол Улсын эдийн засгийн голлох үзүүлэлтүүдэд мэдэгдэхүйц өөрчлөлт орсон,

13.2.3 Бусад

#### АРВАН ДӨРӨВ.ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

14.1 Энэ журмыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол буруутай этгээдэд Монголбанкнаас дараах арга хэмжээг авна.

14.1.1 Их дүнтэй төлбөр тооцоог холбогдох журам, гэрээнд заасны дагуу гүйцэтгээгүй бол холбогдох этгээдэд Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

14.1.2 Энэхүү журмыг хэрэгжүүлэх талаар Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрийг биелүүлээгүй ажилтан, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомж болон Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

#### АРВАН ТАВ. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

15.1 “Банксүлжээ” системд оролцогч талууд нь үүссэн маргааныг харилцан зөвшилцөх байдлаар шийдвэрлэнэ.

15.2 “Банксүлжээ” системд оролцогч талууд нь үүссэн маргааныг харилцан зөвшилцөх байдлаар шийдвэрлэх боломжгүй тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

“Их дүнтэй төлбөрийн системийн журам”-ын  
нэгдүгээр хавсралт

“БАНКСҮЛЖЭЭ” СИСТЕМИЙН ЦАГИЙН ХУВААРИЙГ СУНГАХ ШИЙДВЭР

Огноо	20..... оны .....дугаар сарын ....өдөр
Цаг, минут	.....хүртэл
Шимтгэлтэй эсэх	
Хүсэлт гаргасан оролцогч	
Шалтгаан	

ТТГ-ын захирал ...../...../

“Их дүнтэй төлбөрийн системийн журам”-ын  
хоёрдугаар хавсралт

“БАНКСҮЛЖЭЭ” СИСТЕМД ОРОЛЦОГЧИЙН ХАРИЛЦАХ ДАНС,  
БИК КОДЫН ЖАГСААЛТ

№	Банкны нэр	Харилцах данс	Бик код	6 оронтой код
1	Монголбанк	1607001	BOMUMNUB	010000
2	Капитал банк	3501002	INOVMMNUB	020000
3	Худалдаа, хөгжлийн банк	3501004	TDBMMNUB	040000
4	ХААН банк	3501005	AGMOMNUB	050000
5	Голомт банк	3501015	GLMTMNUB	150000
6	Хадгаламж банк ЭХА	3501217	SVBMMNUB	170000
7	Тээвэр хөгжлийн банк	3501019	TRDMMNUB	190000
8	Ариг банк	3501021	ARGBMNUB	210000
9	Кредит банк	3501022	CRMNMNUB	220000
10	Зоос банк	3501024	ZOOSMNUB	240000
11	Анод банк	3501025	ANODMNUB	250000
12	Улаанбаатар хотын банк	3501026	CIBMMNUB	260000
13	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	3501029	NAIMMNUB	290000
14	Капитрон банк	3501030	CPITMNUB	300000
15	Хас банк	3501032	CAXBMNUB	320000
16	Чингис хаан банк	3501033	CHKHMNUB	330000
17	Төрийн банк	3501034	STBMMNUB	340000
18	Богд банк	3501038	BOGDMNUB	380000
19	Сангийн яамны Төрийн сангийн газар	3401090	MOFUMNUB	900000
20	ҮЦТХТ	3603008	CSDMMNUB	080000
21	АТТ	3603007	SSCHMNUB	070000
22	Хөгжлийн банк	3501036	DEVBMNUB	360000

“БАНКСҮЛЖЭЭ” СИСТЕМИЙН ЛАВЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
АЖИЛТНУУДТАЙ ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

№	Газар, хэлтсийн нэр	Албан тушаал	Утасны дугаар
1	Төлбөр тооцооны газрын бодлого, зохицуулалт, үйл ажиллагааны хэлтэс	Захирал	311445
2	Төлбөр тооцооны газрын бодлого, зохицуулалт, үйл ажиллагааны хэлтэс	“Банксүлжээ” системийн зохицуулагч	310213
3	Тайлан бүртгэлийн газар	Захирал	311445
4	Тайлан бүртгэлийн газрын нягтлан	Ахлах нягтлан бодогч, нягтлан бодогч	327038
5	Мэдээллийн технологийн газар	Захирал	311019
6	Мэдээллийн технологийн газар	Инженер	310150
7	Үндэсний цахим гүйлгээний төв	Захирал	326998 324986
8	Үндэсний цахим гүйлгээний төв	Системийн шинжээч	326998 324986
9	Мөнгөний бодлого, судалгааны газар, Мөнгөний бодлогын хэлтэс	Эдийн засагч	323109

“Их дүнтэй төлбөрийн системийн журам”-ын  
дөрөвдүгээр хавсралт

МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ АЖИЛТНУУДЫН  
ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

Овог нэр	Албан тушаал	Ажлын утас	Гар утас

БАТЛАВ: /гарын үсэг/:

Байгууллагын тамга тэмдэг